“МАНДГОВЬ” ХХК

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, олимп,
Монгол 3000 ХХК-ийн байр, 2-р давхар,
Утас:311946

# “МАНДГОВЬ” ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ШАРТОЛГОЙН АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫГ ИЛ БА ДАЛД АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ДУГААР: MV-017585 ТООТ

АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН
РЕГИСТРИЙН ДУГААР: 2861852

2025 ОН

АГУУЛГА


1.Төслийн танилцуулга..........................................................................1
2.Төсөл хэрэгжиж буй газрын байгаль орчны төлөв байдал, нийгэм ....4
3.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН..5
3.1Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах
3.2Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах
3.3Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах
3.4Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах
3.5Амьтны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ
4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЙЛАН......................................................11
5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН ................11
6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН.............................................................................................11
7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТАЙЛАН................................12
8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН ...........................12
9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН ................................14
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .........................15
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЙЛАН ...............................16
11. БОМТ-ӨӨГ СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ.......................................................................................................18
ХАВСРАЛТУУД ........................................................................................19

## 1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уул уурхай үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг зөв оновчтой тодорхойлж түүнийг арилгах, багасгах, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх нь хариуцлагатай уул уурхайн үндсэн зарчмуудын нэг юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаал болон бусад Монгол улсын хууль, журам, тогтоолын шаардлагад нийцүүлсэн бөгөөд компанийн стратеги төлөвлөгөөнд байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг төлөвлөн тусгасан.

Манай байгууллага хууль, дүрэм журам, стандартын хүрээнд тоосжилт бууруулахад ашиглах усны хэмжээг бууруулах, үйлдвэрт ашиглах гадаргын ус болон газар доорх усны харьцааг нэмэгдүүлэх, биологийн задралд ордог бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх болон хог хаягдлын дахин боловсруулалтыг сайжруулах замаар байгальд хаях хог хаягдлын хэмжээг бууруулах, хүрээлэн буй орчинд учруулж байгаа сөрөг нөлөөллийг ялангуяа агаар бохирдуулагчийг хянах тогтолцоог нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зэрэг гол асуудлуудыг байгаль орчны гол шалгууруудаар тодорхойлсон.

Эдгээр стандарт шаардлага, төлөвлөлт, хариуцлагын хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх ажлыг тус төлөвлөгөөнд тусгав.

Үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харьяалал

Улаанчулуутын алтны үндсэн ордын MV-017585 тусгай зөвшөөрөл бүхий талбай (Зураг 1) нь Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутагт 1712.88 га талбайг эзлэн оршдог. Газар зүйн байршлын хувьд Улаанбаатар хотоос зүүн өмнө зүгт 750 км орчим, Сайншанд хотоос зүүн урд зүгт 180 км, Эрдэнэ сумаас урагш 70 км, Улаанбадрах сумаас зүүн зүгт 65 км, Замын-Үүдийн хилийн боомтоос баруун зүгт 65 км, улсын хилээс хойш 55 орчим км-т тус тус оршино Ордын булангийн цэгүүдийн солбицол:

1. 111º 15' 15.00" 43º 52' 58.00"
2. 111º 15' 15.00" 43º 52' 34.86"
3. 111º 17' 10.06" 43º 52' 34.86"
4. 111º 17' 10.05" 43º 51' 33.00"
5. 111º 11' 46.08" 43º 51' 33.00"
6. 111º 11' 46.08" 43º 52' 58.00"




Зураг 1. Шартолгой алтны үндсэн ордын байршил.




Зураг 2. Улаанчулуутын алтны үндсэн ордын талбайн өндөршлийн зураг.

Газарзүйн онцлог

Ордын талбай нь говийн их мужид хамаарах говийн бэсрэг уулс дунд тэгшивтэр гадарга зонхилсон, намхан хэлхээ уулс, өргөн уудам хөндий тэдгээрийн дунд сунаж тогтсон жижиг толгодууд нь далайн түвшингээс дээш

дунджаар 1100 м -т өргөгдсөн байх бөгөөд хамгийн өндөр цэг нь Улаанчулуут уул 1436.1 м (Зураг 2).

Ус чийг бага, хуурай салхи ихтэй учир ургамлын бүрхэвч тачир сийрэг. Говийн цөлөрхөг хээрийн бүсэд зохицсон ургамал зонхилон ургах ба хазаар, агь, гоёо, таана, бударгана, хөмүүл, эмийн ургамлаас чихэр өвс, цульхир, хулангийн ундаа ургадаг ба бутлаг ургамлаас харгана, шаваг загсгал, модлог ургамлаас хайлаас, тоорой, заг, сухай зэрэг ургадаг.

Ордын геологийн тогтоц

Тус ордын талбай нь региональ бүтцийн хувьд Өвөр Монголын ба Өмнөд Монголын гэсэн хоёр томоохон атираат системийн хэмжээнд Нүхт даваа, Еншөө, Хутаг уул, Сулинхээрийн бүсэд хамаарна.

Геологийн тогтцын хувьд ордын талбай орчмын ихэнх хэсгийг дунд пермийн дэл-овоот формацын вулканоген-тунамал чулуулаг эзлэх ба хойд хэсгээр хожуу Юрийн Эрдэнэтолгой бүрдлийн улаан ягаан өнгийн жижиг-дунд мөхлөгт шүлтлэг боржингийн биет, баруунаас зүүн хойш суналтай нягт цул, шаравтар саарал, ягаавтар өнгөтэй риолит, риодацитын дэл судлуудаар зүсэгдэж, хил заагийн хувиралд бага зэрэг орсон байдаг. Мөн багахан хэсэгт плейстоцен, голоцены сэвсгэр хурдсаар хучигдана. Давхарга зүй:

Доод пермийн Байрам-овоо, Харнүдэн формац;

Дунд пермийн Дэл-овоот формац;

Дунд-дээд юрийн Эрээн-уул формац;

Дээд цэрдийн Баяншірэз, Баруунгоёот формац;

Эоцений Хөвсгөл формац;

Дөрөвдөгчийн (плейстоцен ба голоцений) сэвсгэр хурдас.

Уулын ажлын ерөнхий төлөвлөлт

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Шартолгойн алтны үндсэн ордыг хосолсон аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг (ТЭЗҮ) “Мандговь” ХХК-ийн захиалгаар “Бал чулуу” ХХК-ийн мэргэжилтнүүд боловсруулсан бөгөөд жилд 57.0 мянган тонн хүдэр олборлох хүчин чадалтай байна.

Тус орд нь Галбын говийн цөлөрхөг бүсэд орших бөгөөд A-I, B-I хүдрийн биетүүдийн дээд хэсэгт ил аргаар олборлох боломжтой исэлдлийн бүс (гүн нь 25–35 м, өргөн нь 30–60 м) тогтоогдсон. Ил уурхайн хүрээнд 79.7 кг алт бүхий 42.5 мян.тн хүдрийг 2 жилд олборлож, 657.1 мян.$м^3$ хөрс хуулалт хийгдэхээр төлөвлөсөн. Ашиглалтын 2 дахь жилээс газрын гадаргууд деформацийн аюул үүсэх тул ил уурхайг хааж, далд уурхайгаар үргэлжлүүлэх шийдэл тусгагдсан.

# 2.БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.

## 2.1 Байгаль орчны төлөв байдал

Эрдэнэ сум нь Дорноговь аймгийн баруун урд хэсэгт байрладаг. Сумын газар нутаг нь говийн бүсэд багтах бөгөөд хээрийн болон цөлийн шинж давамгайлсан, хуурай уур амьсгалтай. Сумын нутаг дэвсгэр нь ойролцоогоор 6,800 гаруй км² бөгөөд үүний дийлэнхийг бэлчээрийн газар эзэлдэг.

### Газрын гадарга, ландшафт

Эрдэнэ сумын газар нутгийн ихэнх хэсэг нь нам дор говийн хотгор хөндий, элсэрхэг говь, давсархаг нуур, хуурай сайр, жалга зэрэг олон янзын газрын хэлбэртэй. Ландшафтын хувьд уул толгод багатай бөгөөд говийн нам цээл, чулуун хучилттай гүвээ, жижиг бархантай бүс зонхилдог. Хуурай сайрууд нь борооны улиралд түр зуурын урсац бүхий усны голдирол болдог.

### Уур амьсгал

Сумын уур амьсгал нь эрс тэс, гандуу, хуурай уур амьсгалын мужид хамаарна. Өвлийн улиралд -25°C хүртэл хүйтэрч, зуны улиралд +35°C хүртэл халдаг. Жилд дунджаар 90-120 хоног хүчтэй салхитай байдаг бөгөөд энэ нь газрын эвдрэл, хөрсний элэгдэлд нөлөөлдөг. Хур тунадасны хэмжээ жилд 100-150 мм бөгөөд ихэвчлэн 6–8-р сард төвлөрдөг. Хүчтэй салхины улмаас элс, шороо шуурч, хөрс салхинд элэгдэх үзэгдэл байнга тохиолддог.

### Усны нөөц

Эрдэнэ сум усны нөөц багатай, гүний усны хомсдолтой бүсэд багтдаг. Гол, мөрөн байхгүй бөгөөд байгалийн гаралтай булаг, худгийн усны эх үүсвэрийг ашигладаг. Ундны усны гол эх үүсвэр нь гүний худаг бөгөөд зарим баг сумын төвөөс хол, усны эх үүсвэр хязгаарлагдмал тул усан хангамж хангалтгүй байдаг. Түүнчлэн, газрын доорх усны давсжилт ихтэй, зарим тохиолдолд ундаанд тохиромжгүй байж болзошгүй.

### Хөрс

Сумын нутаг дэвсгэрт голчлон бор хөрс, хүрэн бор хөрс, давсархаг хөрс тархсан. Хөрс нь элсэрхэг, чулуурхаг бүтэцтэй тул ус чийгийг бага хадгалдаг. Малын бэлчээрийн ачаалал ихсэж, бэлчээрийн сэргэх хугацаа удаашИрснаар хөрсний үржил шим буурч байна. Зарим бүс нутгуудад хөрсний элэгдэл, давсжилт, цөлжилт эрчимтэй явагдаж байна.

### Ургамлан бүрхэвч

Ургамлын төрөл зүйл харьцангүй бага бөгөөд ганд тэсвэртэй, хуурай нөхцөлд дасан зохицсон ургамлууд давамгайлдаг. Үүнд гангa, бударгана, хялгана, харгана, хөв хялгана зэрэг зонхилох ургамлууд ордог. Элсний нүүлт ихтэй газарт ургамлын бүрхэвч сийрэг, зарим хэсэг нь бүрэн нүцгэрсэн байдаг. Хэт бэлчээрлэлт, усны хомсдол, хөрсний доройтол зэрэг хүчин зүйлс нь ургамалжилтад сөргөөр нөлөөлж байна.

## 3.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

### 3.1. АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

МандговьХХК-ийн “Шартолгойн алтны үндсэн ордыг ил ба далд аргаар ашиглах” төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд агаарын чанарыг сайжруулах арга хэмжээнд 2 ажлыг төлөвлөн хэрэгжүүлж ажиллаа.

3.1.1 Хөрс хуулалт, барилга байгууламж барих, элс олборлох, тээвэрлэх, овоолго үүсгэх зэргээр тоосжилт үүсэж төсөл хэрэгжих орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлж, улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.

-Уурхайн олборлолт болон бүтээн байгуулалтын явцад зам, талбай засах газар шорооны ажилд ашиглагдах техник, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим өндөр байгаа нь тоосжилтын гол эх үүсвэр болж байна. Төслийн талбайд тоосжилтыг бууруулах зорилгоор авто зам, уурхай доторх талбай, нуруулдан уусгах байгууламжийн суурийн талбайг өдөрт 3 удаа 15 тн усаар усалж байна.

Төслийн хүрээнд 2025 онд үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 10 м/с-с дээш салхитай өдөр 3 удаа тохиож газар шорооны ажлыг уурхайн даргын шийдвэрээр 3 удаа зогсоосон.

3.1.2 Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслүүдийн орчны агаарт бий болгох бохирдлыг багасгах үүднээс тэдгээрт засвар үйлчилгээг тогтмол хийх, чанар сайтай шатах тослох материал хэрэглэх.

-Уурхайд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслүүдийг авто тээврийн үзлэг оношилгоонд хуваарийн дагуу оруулан, засвар үйлчилгээг тогтмол хийж байна. Засвар үйлчилгээг хийж гүйцэтгэхдээ стандартын шаардлага хангасан тос тосолгооны материалыг хэрэглэж байна. Дизель түлшээр ажилладаг тээврийн хэрэгслүүдэд чанарын шаардлага хангасан түлшийг ашиглаж байна.

### 3.2 ГАДАРГЫН БА ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦӨД УЧРУУЛАХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Газрын доорх усанд хэт ачаалал үүсгэхээс урьдчилан сэргийлэх болон ажилчдыг стандартын шаардлага хангасан усаар хангах ажлын хүрээнд 2 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажиллаа.

3.2.1 Ажилчдыг MNS 900:2005 стандартын шаардлага хангасан усаар хангана.

-Ажилчдыг Замын-Үүд суман дахь “Буянт” цэвэр усны үйлдвэрээс эрүүл ахуйн шаардлага хангасан ус зөөвөрлөн хангаж байна.

3.2.1 Уурхайн үйл ажиллагааны явцад газрын доорх усны хэт ашиглалтаас үүдэн тухай орчмын газрын доорх усны түвшин буурах

-Уурхайн үйл ажиллагаанаас газар доорх усны хэт ашиглалт үүсэхээс урьдчилан сэргийлэх, хэрэглээг хянах зорилгоор ашиглалтын 2 худагт стандарт хэмжил зүйн газраар баталгаажуулсан тоолуурыг суурилууллаа.

## 3.3. ХӨРСӨН БҮРХЭВЧИД УЧРУУЛАХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны менежментийн төлөвлөгөөнд 2 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажиллаа.

3.3.1 Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрс бохирдож болзошгүй.

-Нефтийн бүтээгдэхүүнээр бохирдохоос хамгаалах зорилгоор авто засварын газрын 20 м2 талбайг бетонон хучилттай болгож,асгаралт үүсэж болзошгүй засвар үйлчилгээний цэгт асгаралтын иж бүрдлийг байрлуулаад байна.

3.3.2 Олон салаа зам гаргахаас урьдчилан сэргийлэх дотоод замын 2 талаар тэмдэг, тэмдэглэгээ хийх

-Олон салаа зам гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор дотоод болон уурхайн бүс орчимд замын 2 талаар MNS 4597:2014 стандартыг хангасан тэмдэг тэмдэглэгээг 35ш байршуулсан.

## 3.4.ГАЗРЫН ХЭВЛИЙД УЧРУУЛАХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

3.4.1 Газрын хэвлийд далд малталт, хүдэр нуралтаас үүсэх орон зай нь газрын гадаргад цөмрөлт хотойлт үүсгэх магадлалтай

-Төслийн үйл ажиллагаа төлөвлөсөн хугацаанд эхлээгүй улмаар  далд аргаар олборлох ажил хийгдээгүй улмаас дээрх ажил хойшлогдоод байна.

## 3.5.УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд 1 арга хэмжээ төлөвлөсөн боловч уурхайн үйл ажиллагаа 2025 оны хавар, намрын мод тарих хугацаанаас хойш буюу 3 дугаар улиралд эхэлсэнтэй холбоотой 2026 онд тарих суулгацыг бэлтгээд байна.

## 3.6 АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд 1 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажиллаа.

3.6.1 Уурхайн тэсэлгээний үед үүсэх дуу чимээ болон чичиргээ доргилтоос тухайн нутгийн зэрлэг амьтдад шууд физик үйлчлэл, техногенезийн стресс үүсэх, бэлчээр, тэжээлийн хомсдол гарах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

-Уурхай шөнийн цагаар ажиллахгүй байгаа бөгөөд зайлшгүй шөнийн цагаар ажиллах тохиолдолд ажилчдад богино зайн гэрэл асааж байх зааварчилгааг өгч ажиллаж байна.

3.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Биелэлт |
|---|---|---|---|---|
| | **1** | **2** | **3** | **4** |
| 1 | Агаарын чанар | Хөрс хуулалт, барилга байгууламж барих, элс олборлох, тээвэрлэх, овоолго үүсгэх зэргээр тоосжилт үүсч төсөл хэрэгжих орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлж, улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө. | Уурхайн авто замуудыг дулааны улиралд болон тоос ихээр босох үед усалгаа хийж чийгшүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх, 10 м/с ээс дээш салхитай үед газар шорооны ажил хийхгүй байх | Авто зам, уурхай доторх талбай, нуруулдан уусгах байгууламжийн суурийн талбайг өдөрт 3 удаа 15 тн усаар усалж байна. |
| | | Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгсэлүүдийн орчны агаарт бий болгох бохирдлыг багасгах үүднээс тэдгээрт засвар үйлчилгээг тогтмол хийх, чанар сайтай шатах тослох материал хэрэглэх. | Бүх машинд | -Уурхайд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгслүүдийг авто тээврийн үзлэг оношилгоонд хуваарийн дагуу оруулан, засвар үйлчилгээг тогтмол хийж байна.<br>-Тээврийн хэрэгслүүдийг чанарын шаардлага хангасан шатах тослох материалаар хангаж байна. |
| 2 | Гадаргын ба газрын доорхи усны нөөц | Ажилчдыг MNS 900:2005 стандартын шаардлага хангасан усаар хангана. | Энгийн найрлагатай тэсрэх бодисын үйлдвэр агуулах | Замын-Үүд суман дахь "Буянт" цэвэр усны үйлдвэрээс эрүүл ахуйн шаардлага хангасан ус зөөвөрлөн хангаж байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Уурхайн үйл ажиллагааны явцад газрын доорх усны хэт ашиглалтаас үүдэн тухай орчмын газрын доорх усны түвшин буурах | Уурхайн усны ашиглалтыг тогтмол хянах, уурхайн талбайд гүний худаг гаргасны дараагаар худгийг тоолууржуулах, тайлан гаргах | Уурхайн үйл ажиллагаанаас газар доорх усны хэт ашиглалт үүсэхээс урьдчилан сэргийлэх, хэрэглээг хянах зорилгоор ашиглалтын 2 худагт Стандарт хэмжил зүйн хэлтсээр баталгаажуулсан тоолуурыг суурилууллаа. |
| 3 | Хөрсөн бүрхэвч | Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрс бохирдож болзошгүй. | Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд даган мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах | -Нефтийн бүтээгдэхүүнээр бохирдохоос хамгаалах зорилгоор авто засварын газрын 20 м2 талбайг биетонон хучилттай болгож,асгаралт үүсэж болзошгүй засвар үйлчилгээний цэгт асгаралтын иж бүрдлийг байрлуулаад байна. |
| 4 | | Олон салаа зам гаргахаас урьдчилан сэргийлэх дотоод замын 2 талаар тэмдэг, тэмдэглэгээ хийх | Энгийн найрлагатай тэсрэх бодисын үйлдвэр агуулах | Олон салаа зам гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор дотоод болон уурхайн бүс орчимд замын 2 талаар MNS 4597:2014 стандартыг хангасан тэмдэг тэмдэглэгээг 35ш байршуулсан. |
| 5 | Газрын хэвлий | Газрын хэвлийд далд малталт, хүдэр нураалтаас үүсэх орон зай нь газрын гадаргад цөмрөлт хотойлт үүсгэх магадлалтай | Далд уурхайн хаалт MNS 6296 :2011 стандартын дагуу хийж гүйцэтгэх | Төслийн ажил хугацаа хоцрогдолтой явагдаж байгаа тул далд уурхайн олборлолт хийгдээгүй байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6 | Ургамлан нөмрөг | 24.06 га талбайн ургамлан нөмрөг дарагдаж, үндсэн хэв шинжийг алдах | Уурхайн ажилчдын тосгоны нийт талбайн 10% болох 0.5 га талбайг зүлэгжүүлэх | Уурхайн үйл ажиллагаа хавар намрын мод тарих хугацаанаас хойш эхэлсэнтэй холбоотой 2026 онд тарихаар суулгацыг бэлтгээд байна. |
| 7 | Амьтны аймаг | Уурхайн тэсэлгээний үед үүсэх дуу чимээ болон чичиргээ доргилтоос тухайн нутгийн зэрлэг амьтдад шууд физик үйлчлэл, техногенезийн стресс үүсэх, бэлчээр, тэжээлийн хомсдол гарах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлнэ | Уурхайн үйл ажиллагааг шөнийн цагаар аль болох явуулахгүй байх, суурин ашиглагдах техникүүд богино зайн гэрлээ ашиглах хэрэгтэй | Уурхай шөнийн цагаар ажиллахгүй байгаа бөгөөд зайлшгүй шөнийн цагаар ажиллах тохиолдолд ажилчидад богино зайн гэрэл асааж байх зааварчилгааг өгч ажиллаж байна. |
| | Нийт | | | |

## 4.ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Орчны тохижилт нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд 1 ажлыг төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажиллаа.

1.Уурхайн 2025 онд техникийн болон биологийн нөхөн сэргээт төлөвлөгдөөгүй.
2.Орчны тохижилт ажлын хүрээнд хог хаягдлыг 3 төрлөөр ангилах зориулалтын сав хийж байршуулсан.

| Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Биелэлт |
|---|---|---|
| 1 | 2 | 3 |
| Техникийн нөхөн сэргээлт | Төлөвлөгдөөгүй | - |
| Биологийн нөхөн сэргээлт | Төлөвлөгдөөгүй | - |
| Орчны тохижилт | Хатуу хаягдлыг ахуйн гарал үүслээр нь ялган ангилж, хураан хуримтлуулах зориулалтын цэгт хогийн сав байршуулах | Хог хаягдлыг 3 төрлөөр ангилах зориулалтын сав хийж байршуулсан. |

## 5.БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны Байгаль оряны менежментийн төлөвлөгөөнд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ төлөвлөгдөөгүй

## 6.НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

-Төлөвлөгдөөгүй

## 7.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

| Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хүрээ | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| Археологийн дурсгал, Палентологийн дурсгал | Түүх, соёлын өвийн дурсгалт зүйл илрээгүй байгаа болно | ЭНТБҮА-ын орчин | Түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй учраас арга хэмжээ төлөвлөгдөөгүй |
| Нийт | | | |

### 8.Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

| **№** | **Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө** | **Нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээ** | **Арга хэмжээний цар, хэмжээ** | **Биелэлт** |
|---|---|---|---|---|
| 1 | Газар хөдлөлт | Зохих зураг төслийн стандартыг ашиглан гүйцэтгэгч байгууллагад шаардлага тавих, байгууламжийг улсын комисст хүлээлгэн өгөх | Төслийн талбай | Аж үйлдвэр, Эрдэс баялгийн яамны 2025 оны 25/27 дугаарт улсын комиссын актаар хүлээн авсан. |
| 2 | Аянга цахилгаан | Аянга зайлуулагчийг ЦС-ын байгууламжийн ойролцоох өндөрлөг газруудад суурилуулах. ЦС-ын цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх | Төслийн талбай | Цахилгааны эх үүсвэрийг зөөврийн цахилгаан үүсгүүрээр хангаж байгаа болно. Одоогоор өндөр хүчдэлийн шугамд |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | холбогдоогүй тул аянга зайлуулагч шаардлагагүй. |
| 3 | Аадар бороо | Барилга байгууламжуудын зураг төсөл, чанарт цаг агаарын нөхцөлүүдийг тусгах, уурхайг үерээс хамгаалсан далан байгууламжтай болгох | Төслийн талбай | 2026 оны хавар уурхайн үерээс хамгаалах далан байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. |
| 4 | Шороон шуурга | Уурхайд онцгой байдлын журам боловсруулан мөрдөж ажиллах | Төслийн талбай | ОБЕГ-н дэргэдэх уул уурхайн аврах ангиар гамшигаас хамгаалах төлөвлөгөөг батлуулан мөрдөн ажиллаж байна. |
| 5 | Халдварт өвчин | Өндөр эрсдэлтэй амьтадтай (шувууд) харьцахгүй байх хангалттай хэмжээний хамгаалалтын хэрэгсэлтэй байх (амны хаалт гэх мэт) | Төслийн талбай | Өндөр эрсдэлтэй амьтадтай харьцах, халдварт өвчний үед ашиглах амны хаалт 100ш, бээлий 200, нэг удаагийн хувцас 20 ш-г нөөцөд бэлтгээд байна. |
| 6 | Нефть болон химийн аюултай бодис асгарах | Ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт зэрэгт анхаарал хандуулж холбогдох журам боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай. | Төсөл хэрэгжих бүс нутаг | Уурхайн ашиглалтын үед нефтийн бүтээгдэхүүн болон химийн бодис асгарах үед хэрэгжүүлэх журмыг боловсруулан ажиллаж байна. |

9.Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

| № | Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Ахуйн | Уурхайн ахуйн хатуу хог хаягдалд хоол хүнс, түлш, угаалга цэвэрлэгээний материалын сав, баглаа боодол болох мод, цаасан хайрцаг, хуванцар болон шил сав, гялгар уут зэрэг материалуудыг цуглуулаад хуванцар, шил, төмөр ба бусад төрлөөр нь хуваан ангилж, цааш ашиглах боломжгүй хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэг рүү зөвшөөрөлтэй ААН-ээр зайлуулулах, | Уурхай орчин | Уурхайн байршилд үүсэх хог хаягдлыг 3 төрлөөр ангилан ялгаж хадгалах сав 1ш хийж байрлуулсан. Мөн Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газартай хог хаягдал тээвэрлэн хогийн төвлөрсөн цэгт хүргэх 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаартай гэрээг байгуулсан. |
| | | Ахуйн хог хаягдлыг ангилж зориулалтын хогийн саванд хадгалах | Уурхай орчин | Үүссэн хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын саванд эх үүсвэр дээр нь түр хадгалж байна. |
| | | Халдваргүйжүүлэх, нян устгах ариутгалыг орон нутгийн мэргэжлийн байгууллагаар хийлгэх, | Уурхай орчин | “Баялаг шанд” ХХК-тай ариутгал халдваргүйжүүлэлтийн гэрээг байгуулсан. |
| 2 | Уурхайн | ШТМ-ын хаягдлыг битүүмжлэл сайтай хадгалж байгаад хаягдал тос боловсруулах үйлдвэрт тушаах | Уурхай орчин | Шатах тослох материалын хаягдлыг битүүмжлэл сайтай төмөр болон хуванцар саванд хадгалж байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Хатуу хаягдлыг ахуйн гарал үүслээр нь ялган ангилж, хураан хуримтлуулах зориулалтын цэгт хогийн сав байршуулах | Уурхай орчин | Хатуу хог хаягдлыг шил, хуванцар, хаягдал цаас гэсэн 3 төрлөөр ангилан ялгаж хадгалах сав 1ш хийж байрлуулсан |
| **3** | Аюултай | Аюултай хог хаягдал тээвэрлэх, хадгалах, устгах үйл ажиллагаа эрхэлдэг эрх бүхий нэгж байгууллагатай гэрээ байгуулан нийлүүлэх, | Уурхай орчин | Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, устгах ажил гүйцэтгэх гэрээг “Элемент”ХХК-тай байгуулсан. |

10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Тоо, хэмжээ | Биелэлт |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Агаар дахь хорт хийн агууламж | -Мониторингийн цэг буюу нөлөөлөлд өртөөгүй газар<br>-Уурхайн камп | Жилд 2 удаа | Байгаль орчны менжментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу агаарын шинжилгээг 4 улиалд 1 удаа хийлгэлээ агаарын шинжилгээгээр стандарт хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй байна. |
| 2 | Агаар дахь тоосонцорын хэмжээ /$PM_{10}$ / | -Уурхай орчим | Жилд 2 удаа | Агаар дахь нийт тоосны хэмжээг аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор 4 дүгээр улиралд 1 удаа хийлгэсэн. Лабораторийн сорилтын дүнгээр агаар дахь нийт |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | тоосны хэмжээ стандарт хэмжээнд байна. |
| 3 | Хөрсний хими чанар | Уурхай бүс, камп орчимд | Жилд 2 удаа | Уурхай орчмын хөрсний агрохимийн шинжилгээг аймгийн Ус цаг, Уур орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторийн шинжилгээнд хамруулсан./Шинжилгээ хийх багажийг Стандарт хэмжил зүйн төвд баталгаажуулахаар явуулсантай холбоотой шинжилгээний хариу гараагүй байна./ |
| 4 | Усны чанар | Үйлдвэрийн ундны ус | Жилд 2 удаа | Ундны усны шинжилгээг Дорноговь аймгийн Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн сорилтын лабораторид 10-р сард 1 удаа хийлгэсэн. |
| 5 | Бэлчээрийн төлөв байдал ургамлан нөмрөг | Төслийн нөлөөллийн талбайд | Жилд 2 удаа | Уурхай орчмын бэлчээрийн төлөв байдал, ургамлан нөмрөгийн судалгааг аймгийн Цаг, Уур орчны шинжилгээний төвөөр хийлгэсэн. |

## 11.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | Биелэлт |
|---|---|---|---|
| | 1 | 2 | |

| | | | |
|---|---|---|---|
| 1 | Хавар (5 сар), намар (10 сар) байгаль орчныг хамгаалах, ялангуяа ус, хөрс, ургамлыг хамгаалахтай холбогдсон сургалтыг өөрийн ажиллагсдын дунд зохион байгуулж дүгнэж байх. | 400,0 | ус, хөрс, ургамлыг хамгаалахтай холбогдсон сургалтыг өөрийн ажиллагсдын дунд зохион байгуулж 30 ажилчдыг хамруулллаа. |
| 2 | Болзошгүй аюул ослын үед орон нутгийн эмнэлэг бусад байгууллагатай хамтран ажиллах. | 300,0 | Компанийн ажилчдыг Замын-Үүд сумын эмнэлэгт үзлэгт хамруулсан. Мөн Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллаж байна. |
| 3 | Байгаль хамгаалах талаар сурталчилгаа зохион байгуулах. | 400,0 | Компанийн ажилчдад аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан хадгалах талаарх сургалтыг 12 ажилтанд зохион байгууллаа. |
| 4 | Ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр сургалтыг системтэй зохион байгуулах. | 400,0 | Хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр 20 ажилтанд сургалт зохион байгуулсан |
| 5 | Хатуу, шингэн хог хаягдлыг битүү саванд хуримтлуулж тухай бүрд нь хогийн цэгт хаях, ариутгах бие засах газрыг хлорын шохойн 5-10 %-ийн уусмалаар ариутгаж байх | 1000,0 | -Шингэн хаягдлыг хөрсөнд үл нэвчүүлэх материалаар доторлосон цооногт цуглуулж байна.<br>-Хатуу хог хаягдлыг 3 төрлөөр ангилан ялгаж гал, усанд тэсвэртэй материалаар хийгдсэн төмөр хийц бүхий саванд хуримтлуулж байна.<br>-“Баялаг шанд” ХХК-тай ариутгал халдваргүйжүүлэлтийн гэрээг байгуулсан. |
| 6 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг талуудад тайлагнах төсөв | 400,0 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сумын Засаг даргын тамгын газарт хүргүүлэн ажилласан. |
| 7 | Уурхайн эдэлбэр газар дотроос түүх дурсгалын болон ямар нэгэн нэн ховор олдвор олдвол газар шорооны ажлыг зогсоож мэргэжлийн байгууллагад хандан яаралтай арга хэмжээ авна | 400,0 | Уурхайн хөрс хуулалт болон газар шорооны ажлын үед түүх дурсгалын болон ховор олдвор олоогүй байна. Олдсон тохиолдолд ажлыг зогсоож зохих шатны албан тушаалтанд мэдэгдэх талаар заавар зөвлөмжийг ажилчдад танилцуулан ажилласан. |

| | | | |
|---|---|---|---|
| **8** | Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээх ажлын хүрээнд орон нутгийн удирдлагатай хамтран ажиллана | 3,600,0 | Эрдэнэ сумын Засаг даргатай 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан хамтран ажиллах гэрээнд газрын нөхөн сэргээлтийг хийж орон нутагт хүлээлгэн өгч акт үйлдэж байхаар тусгаад байна. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 2026 онд тарих ....... ширхэг суулгацыг ............ худалдан авч бэлтгээд байна. |
| **9** | Хог хаягдлын гэрээ байгуулан ажиллаж хог хаягдлын төлбөр төлөх | 500,0 | Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газартай хог хаягдал тээвэрлэн хогийн төвлөрсөн цэгт хүргэх 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 03 дугаартай гэрээг байгуулсан. Мөн хог хаягдлын төлбөр 240.0 мян.төг Эрдэнэ сумын төрийн санд байршуулсан. |
| **Нийт** | | **7,400.0** | |

## 12.ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

| № | БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Биелэлт |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **1** | Уурхайн удирдлага, Эрдэнэ сумын ЗДТГ, Иргэд | Хурал болон цахим хэлбэрээр | Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлт | Эрдэнэ сумын Засаг даргын тамгын газарт төлөвлөгөөний биелэлтийг гаргаж албан бичгээр хүргүүлсэн. |

ХАВСРАЛТ









MNAS Accreditation system

[illegible]

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН СОРИЛТЫН ЛАБОРАТОРИ**

Дорноговь аймаг, Сайншанд сум, 2-р баг

Утас: 70523891

**ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**
***CERTIFICATE OF ANALYSIS***

**Бүртгэлийн дугаар** */Registration number/* : 25-523
**Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан газрын нэр :** Б.Гэрэлтуяа
*/The name of customer's request for analysis/*
**Дэд лабораторийн нэр** */Name of the sub laboratory/* : Эрүүл ахуйн нян судлалын хяналтын лаборатори

| Дээжийн тодорхойлолт /Sample description/ | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Дээжийн дугаар *Sample number* | Дээжийн нэр *Name of sample* | Цувралын дугаар *Batch number* | Үйлдвэрлэсэн улс *The country of original manufacturer* | Бүтээгдэхүүний хүчинтэй хугацаа *Date of expiry* | Дээжийн тоо хэмжээ *Quantity of the sample* |
| 2487 | Булгийн цэвэр ус | | Монгол Улс | Тодорхойгүй | 250.0 мл |

| Хүлээн авсан огноо *Date of receipt* | Шинжилгээ дууссан огноо *Date of test completion* | Хэвлэсэн огноо *Date of issue of the report* |
|---|---|---|
| 2025 он 10 сар 27 өдөр | 2025 он 10 сар 31 өдөр | 2025 он 10 сар 31 өдөр |

| Дээжийн дугаар *Sample number* | Шинжилгээний аргын стандарт *Method of analysis* | Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж *Test parameter, unit* | Шаардлага *Test specification, unit* | Шинжилгээний дүн *Test results* |
|---|---|---|---|---|
| 2487 | MNS 6546:2015 | *Pseudomonas aeruginosa* | Илрэхгүй | Илрээгүй |
| | MNS 5007:2022 | БББТ | 20 | 6 |
| | MNS ISO 19250:2017 | *Salmonella spp* | Илрэхгүй | Илрээгүй |
| | MNS ISO 9308-2:1998 | Халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян /ялгас шүүлтүүр/ | Илрэхгүй | Илрээгүй |
| | MNS ISO 19250:2017 | *Shigella spp* | Илрэхгүй | Илрээгүй |

**Санал тайлбар:**
*Opinions and interpretation*

**БАТАЛСАН:** ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ:
*Approved by*

/Б .САЙХАНБАЯР/

[illegible]

ЛАБОРАТОРИ

[illegible]






АНХААР!
КАРЬЕР


20


5


ЦУГЛАХ ЦЭГ





Төлсөн баримт

МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

